ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2025/11/НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дундговь аймаг<br>2025 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Т.Батсайхан<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn<br><br>Аудитор: Ж.Угтахбаяр<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


........................................................................................................0
1.Аудитын санал дүгнэлт........................................................................2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..............3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..........................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........................................4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ......................5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..............................................5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан...........................................6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ...............................6
3. Аудитын илрүүлэлт.............................................................................7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....................................16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## 1.Аудитын санал дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.03.25 № 92

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 221.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
2. Орон нутгийн хөгжлийн сангаас 10.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
3. Мал хамгаалах сангаас дутагдсан өвс, тэжээлийн 9.7 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1, 71.1.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс **3.8** дахин их, зардлыг жишиг хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь авлага болон хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүг барагдуулах арга хэмжээ аваагүй нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр

4825020313

сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, сумын бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос өссөн байна. Орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 5 албан хаагч 35.7 сая төгрөгийн дэмжлэг өгсөн байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл 2023 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлангаас 12.3 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл, улсын төсвийн байгууллагын төвлөрүүлсэн дүнг устгал хийсэнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 34 зорилт, 95 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хугацаа хоцроож, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,394,416.9 | 4,046,078.8 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,034,301.3 | 2,889,032.2 |
| 32 | БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 0.0 | 0.0 |
| 33 | АВЛАГА | 991,391.7 | 747,252.3 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 0.0 | 0.0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 292,233.9 | 333,304.4 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 0.0 | 0.0 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 76,490.0 | 76,490.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,821,145.6 | 2,789,529.8 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,821,145.6 | 2,789,529.8 |
| 39100 | Газар | 0.0 | 0.0 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,623,866.6 | 2,576,101.0 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 197,279.0 | 213,428.7 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,215,562.4 | 6,835,608.6 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 11,416.9 | 185,972.8 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 11,416.9 | 185,972.8 |
| 41300 | Өглөг | 11,416.9 | 185,972.8 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,204,145.6 | 6,649,635.8 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,204,145.6 | 6,649,635.8 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 677,666.3 | 677,666.3 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 4,418,260.2 | 5,863,750.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 108,219.0 | 108,219.0 |
| 52 | Хяналтын бус хувь оролцоо | 0.0 | 0.0 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,215,562.4 | 6,835,608.6 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 7,494,026.4 | 11,379,343.4 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 5,130,253.6 | 9,157,629.8 |
| 110 | Орлогын албан татвар | 4,684,278.3 | 8,473,549.6 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 4,684,278.3 | 8,473,549.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 224,227.3 | 273,425.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 221,748.0 | 410,654.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,487,940.8 | 796,593.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,487,940.8 | 796,593.3 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,832.0 | 1,425,120.4 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 5,842,896.8 | 8,453,848.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,842,896.8 | 8,453,848.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,420,229.7 | 4,573,874.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 769,658.3 | 1,135,011.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,449.8 | 140,291.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,479.4 | 1,999,382.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 127,219.1 | 191,842.2 |
| 2105 | Нормативт зардал | 0.0 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,385.0 | 194,435.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,158.0 | 4,520.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,673,454.2 | 111,820.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 655,425.8 | 796,571.7 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,422,667.1 | 3,879,974.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,651,129.6 | 2,925,494.6 |

| | | | |
|---|---|---|---|
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 735,507.0 | 1,305,566.3 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 915,622.6 | 1,619,928.2 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,294,747.4 | 0.0 | 4,294,747.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -6,224.4 | 0.0 | -6,224.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,288,523.0 | 0.0 | 4,288,523.0 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 915,622.6 | 0.0 | 915,622.6 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,204,145.6 | 0.0 | 5,204,145.6 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 5,204,145.6 | 0.0 | 5,204,145.6 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -174,437.9 | 0.0 | -174,437.9 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,029,707.6 | 0.0 | 5,029,707.6 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,619,928.2 | 0.0 | 1,619,928.2 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 6,649,635.8 | 0.0 | 6,649,635.8 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 7,151,807.4 | 11,349,114.8 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 5,130,253.6 | 9,157,629.8 |
| 110 | Орлогын албан татвар | 4,684,278.3 | 8,473,549.6 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 4,684,278.3 | 8,473,549.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 224,227.3 | 273,425.3 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 221,748.0 | 410,654.9 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 117,936.1 | 151,892.7 |
| 1181 | Газрын төлбөр | 103,461.9 | 258,762.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 350.0 | 0.0 |
| 1183 | Бусад татвар | 0.0 | 0.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,145,721.8 | 766,364.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,145,721.8 | 766,364.7 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 0.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,832.0 | 1,425,120.4 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,426,374.4 | 8,174,933.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,426,374.4 | 8,174,933.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,003,707.3 | 4,294,958.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 769,933.0 | 1,135,011.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 95,449.8 | 140,291.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 66,479.4 | 1,999,382.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 83,560.9 | 61,350.2 |
| 2105 | Нормативт зардал | 0.0 | 0.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,333.0 | 197,133.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,158.0 | 4,520.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,673,454.2 | 108,850.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 273,339.1 | 648,420.4 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,422,667.1 | 3,879,974.8 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,725,433.0 | 3,174,181.3 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 0.0 | 0.0 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 898,515.2 | 1,319,450.5 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 898,515.2 | 1,319,450.5 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 898,515.2 | 1,319,450.5 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -898,515.2 | -1,319,450.5 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -348,000.0 | 0.0 |
| 14 | Бусад эх үүсвэр | 0.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 348,000.0 | 0.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 478,917.8 | 1,854,730.9 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 555,383.5 | 1,034,301.3 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,034,301.3 | 2,889,032.2 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,966,243.6 | 5,696,120.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,825,916.1 | 4,396,233.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,609,767.8 | 4,206,086.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,206,328.5 | 1,135,011.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 151,065.9 | 140,291.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,143,277.7 | 1,998,110.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 65,762.8 | 58,164.3 |
| 2105 | Нормативт зардал | 1,286.8 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 221,216.5 | 208,352.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,957.0 | 4,236.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 41,108.7 | 33,955.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 773,763.9 | 627,965.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 216,148.3 | 190,147.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 216,148.3 | 190,147.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,524,327.5 | 1,299,886.6 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 616,000.0 | - |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 6,966,243.6 | 6,317,663.8 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,335,210.8 | 1,281,802.8 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,813,454.1 | 4,718,596.3 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 817,578.7 | 317,264.6 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 481,142.5 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 814,107.2 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 143,317.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 143,317.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 99,635.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,271.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,185.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 284.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 74,894.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,000.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,681.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,150.0 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 39,531.7 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 143,317.6 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 143,317.6 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |

| | | |
|---|---|---|
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын илрүүлэлт

### *3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй. Харин Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 79,705.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 69,956.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 9,749.0 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### *3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | **5** | | | **1** | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,920,877.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,275,880.3 мянган төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 55,161.6 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 589,836.0 мянган төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 33.6 хувийг залруулагдаагүй, 66.4 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 644,997.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 37.3 хувь буюу **240,530.8** мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 62.7 хувь буюу 404,466.8 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ. Дээрх завсрын аудитаар илэрсэн зөрчлүүдийг жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжүүлж, хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 252,985.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 186,488.8 мянган төгрөгөөр буюу 3.8 дахин их байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** /мянган төгрөг/

| Байгууллгын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг даргын Тамгын газар | 3 | 976,264.0 | 3 | 976,264.0 | 3 | 976,264.0 | 3 | 976,264.0 | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2 | 222,095.4 | 2 | 222,095.4 | 2 | 222,095.4 | 2 | 222,095.4 | | | | |
| Мал хамгаалах сан | 1 | 69,956.5 | 1 | 69,956.5 | 1 | 69,956.5 | 1 | 69,956.5 | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 1,194.2 | 1 | 1,194.2 | 1 | 1,194.2 | 1 | 1,194.2 | | | | |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 1 | 6,370.2 | 1 | 6,370.2 | 1 | 6,370.2 | 1 | 6,370.2 | | | | |
| Дүн | **8** | **1,275,880.3** | **8** | **1,275,880.3** | **8** | **1,275,880.3** | **8** | **1,275,880.3** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 3 | 625.5 | | | 3 | 625.5 | | | | | | |
| Засаг даргын Тамгын газар | 6 | 2,002.4 | 1 | 2,002.4 | 5 | 240,530.8 | | | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 53,159.3 | 1 | 53,159.3 | | | | | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1 | 338,930.6 | | | 1 | 10,000.0 | | | | | | |
| Мал хамгаалах сан | 1 | 9,749.0 | | | 1 | 9,749.0 | | | | | | |
| **Нийт дүн** | **12** | **316,067.0** | **2** | **55,161.6** | **10** | **260,905.4** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил:** | | | | | | | | | | | | |
| Орон нутгийн хөгжлийн сан | 5 | 328,930.6 | | | 5 | 328,930.6 | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | **5** | **328,930.6** | **-** | **-** | **5** | **328,930.6** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |